



ДУНГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2016 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 06

Мандалговь

Хөрөнгө данснаас хасах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Орон нутгийн өмчийн албаны үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 17,714,700 /арван долоон сая долоон зуун арван дөрвөн мянга долоон зуу/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн Дуа 62-03 улсын дугаартай Land Cruiser 70 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 4,000,000 /дөрвөн сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дарьбумд үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Орон нутгийн өмчийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Дарьбумд даалгасугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

8308116